



**ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 03 сарын 20-ны өдөр

Дугаар 4/7

Эрдэнэт

“Давсны хэрэглээг бууруулах өдрийг  
тэмдэглэн өнгөрүүлэх тухай”

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалт, Засгийн газрын 2001 оны 224 дүгээр тогтоолын хавсралт “Эрүүл аж төрөх зан үйлийг төлөвшүүлэхэд чиглэсэн мэдээлэл, сургалт, сурталчилгааны төлөвлөгөө”, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2020 оны 03 дугаар сарын 05-өдрийн 106 тоот албан бичгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Давсны хэрэглээг бууруулах дэлхийн өдрийг зохион байгуулах ажлын хэсгийг нэгдүгээр, үйл ажиллагааны удирдамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Үйл ажиллагааг зохион байгуулахад шаардлагатай 120.000 /нэг зуун хорин мянган төгрөг/-ийг холбогдох эрх зүйн хүрээнд шийдвэрлэхийг Салбарын санхүү бүртгэл мэдээлэл нягтлан бодохын ажилтан /Н.Чулуун-Эрдэнэ/-д зөвшөөрсүгэй.
3. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж үр дүнг тооцон тайлagnаж ажиллахыг Хоол тэжээл хүнсний аюулгүй байдлын асуудал хариуцсан мэргэжилтэн /Т.Байгаль/-д даалгасугай.

ДАРГА

Ц.МОНХЦЭЦЭГ

Эрүүл мэндийн газрын даргын 2020 оны  
11 дугаар сарын 20-ны өдрийн  
11 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

## АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДХҮҮН

Ажлын хэсгийн дарга:

- Нийгмийн эрүүл мэндийн төвийн дарга

Гишүүд:

- Эрүүл мэндийн газрын Эрүүл мэндийн боловсрол, мэдээлэл сургалт  
сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн

Нарийн бичиг:

- Эрүүл мэндийн газрын зураглаач  
- БОЭТ-ийн сурьеэгийн кабинетийн диспансер  
- Монголын сурьеэтэй тэмцэх нийгэмлэгийн ажилтан  
- Амьсгалын зам, сурьеэгийн асуудал хариуцсан мэргэжилтэн

"ДАВСНЫ ХЭРЭГЛЭЭГ БУУРУУЛАХ ДЭЛХИЙН ӨДӨР"-ИЙГ ТЭМДЭГЛЭН  
ӨНГӨРҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ УДИРДАМЖ

**Үндэслэл:** Монгол Улсын хүн амын нийт нас баралтын 77 хувийг халдварт бус өвчин (ХБӨ) эзэлж, 15-64 насны 3 хүн тутмын нэг нь 70 нас хүрэхээсээ өмнө зүрх судасны өвчин, чихрийн шижин, хавдрын шалтгаанаар нас барах эрсдэлтэй байна. Насанд хүрсэн 10 хүн тутмын найм нь хоногт 5 граммаас их (дунджаар 11 г) давс хэрэглэж, үйлдвэрийн аргаар боловсруулсан хүнсний 83.6%, хоол үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний 81.6% нь давсны орцыг хэтрүүлэн үйлдвэрлэсэн байна.

Нэгдсэн Үндэсний Байгууллагын "Тогтвортой хөгжлийн зорилт 2030"-д дэлхийн хүн амын давсны хэрэглээг 2025 он гэхэд 30% хүртэл бууруулах зорилт дэвшүүлсэн.

Монгол Улсын "Давсны хэрэглээг бууруулах үндэсний стратеги (2015-2025) он"-д хүн амын давсны хэрэглээг 2025 он гэхэд 2013 оны түвшингээс 30%-иар, хүнсний бүтээгдэхүүний давсны агууламжийг 40%-иар, нийтийн хоол үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний давсны агууламжийг 40%-иар бууруулахаар тус тус заасан.

Орхон аймагт 2019 онд "Давс багатай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжье" аяныг зохион байгуулж 22 аж ахуй нэгж байгууллагуудын 80 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүний давсны агууламжийг 58,3 хувиар бууруулсан.

**Зорилго:** Хүн амын болон хүнсний үйлдвэрлэл, худалдаа эрхлэгчдийн давсны хэрэглээний талаарх мэдлэг, хандлагыг дээшлүүлэх.

**Хэрэгжүүлэгч байгууллага:** Орхон аймгийн Эрүүл мэндийн газар – Нийгмийн эрүүл мэндийн төв

**Хамтран ажиллах байгууллагууд:** БОЭТ, Сум, Өрхийн эрүүл мэндийн төвүүд, Медипас төв эмнэлэг, Эрдэнэт сувиллын цогцолбор

**Хугацаа:** 2020 оны 03 дугаар сарын 13-аас -23-ныг хүртлэх өдрүүдэд

## ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хугацаа	Хаана	Хамтран зохион байгуулагчид	Хүрэх үр дүн
1	Аяны удирдамж, төлөвлөгөөг батлуулж хамтран зохион байгуулагч байгууллагуудад хүргүүлэх	03 сарын13	НЭМТ	ХХААГ, ЭМБ-үүд Үйлдвэр, аж ахуй нэгж байгуулага	Удирдамж төлөвлөгөө хүргэгдсэн байна.
2	“Давсны хэрэглээг бууруулья” цахим аянд нэгдэхийг уриалах	03 сарын 13	НЭМТ	ЭМБ-үүд Үйлдвэр, аж ахуй нэгж байгуулага	Аянд хамрагдсан хүний тоо
3	НЭМҮТ-еес боловсруулсан давсны хэрэглээний талаарх зурагт хуудас видео шторкуудыг татан авч Эрүүл мэндийн газрын цахим хуудсанд байршуулан цахимаар түгээх	03 сарын 13	НЭМТ	ЭМБ-үүд Үйлдвэр, аж ахуй нэгж байгуулага	Эрүүл мэндийн газрын цахим хуудсанд байршуулсан зурагт хуудас видео шторкийн татан авч түгээсэн, шейр хийсэн хүний тоо
4	Давс багтай бүтээгдэхүүн үйлдвэрлээ 2-р аянд амжилттай оролцсон аж ахуй нэгж байгуулагын сайн туршлага, санаачлагыг нийтэд сурталчлах	03 сарын13-наас 03 сарын 24	НЭМТ	ХХААГ, Хэвлэл мэдээлэйн байгуулага	Нэвтрүүлэг гарсан байна.
5	·Ажилчдын хоолны давсыг багасгах, цайг давсгүй хийх уриалгыг үйлдвэр аж ахуй нэгж байгууллагуудад хүргүүлэх	03 сарын 13	НЭМТ	ЭМБ-үүд Үйлдвэр, аж ахуй нэгж байгуулага	Уриалгад нэгдсэн байгуулагын тоо
6	Та худалдан авдаг хүнсний бүтээгдэхүүнд хэр зэрэг их давс агуулагдаж байгааг шалгаж мэдэх үү? болзолт уралдаан зохион байгуулах	03 сарын 17-наас 03 сарын 31	НЭМТ	Иргэдийн дунд	Уралдааны дүн

УДИРДАМЖ БОЛОВСРУУЛСАН: ХТХАБАХМ

Т.Байгаль

ХЯНАСАН: СТҮХМ

А.БАЯРХҮҮ

## АЯНЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨСӨВ:

Орхон аймаг

2020.03.17

№	Зардлын төрөл	Хэмжих нэгж	Нэг бүрийн үнэ	Тоо хэмжээ	Нийт үнэ /төг/
Болзолт уралдааны төсөв					
1	1-р байр / Ном/	ширхэг	50.000	1	50.000
2	2-р байр / Ном/	ширхэг	40.000	1	40.000
3	3-р байр / Ном/	ширхэг	30.000	1	30.000
Нийт дүн					120,000

ТӨСӨВ ГАРГАСАН: ЭМЭЗТТХМ:

Д.ОТГОНДЭЛГЭР

ХЯНАСАН: ССБМНБ

С.ЧУЛУУН-ЭРДЭНЭ